

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:


“VII.5. Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг биелэлтийг бүрэн хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч дүнг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний дотор танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгав.

2. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх, эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зарласан болон гаргасан хувьцааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгүүлж хадгалах, Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа хувьцааны бүртгэлийг баталгаажуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва нарт даалгав.

3. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сангаас Монгол Улсын иргэдийн мэдээллийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2018 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хүргүүлэхийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүд, өөрчлөлт орсон мэдээллийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулж байхыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагвад тус тус даалгав.

4. Тавантолгойн ордыг цогцоор нь эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбогдсон эрчим хүч, зам, тээвэр, усан хангамж, хилийн боомт зэрэг тус тусын эрхэлсэн асуудлын хүрээнд хамаарах дэд бүтцийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломж, хувилбарыг судлан авах арга хэмжээний талаар санал боловсруулж зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон холбогдох бусад сайд нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР